# ОРХОН АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Баян-Өндөр сум

| д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Стратеги төлөвлөгөөний зорилт-1. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдралын зан төлөв насан туршийн дадал олгох зорилт бүхий биеийн тамирын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх; | | | | | | | |
| Биеийн тамир, спортын тухай хуулийн 13.1, 14.1 заалт, Соёл спорт аялал жуулчлал залуучуудын сайд, Орхон аймгийн Засаг даргатай 2025 онд байгуулсан гэрээний 4.7 заалт, Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.5.1 заалт, Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1.1 заалт, Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө; | | Улсын төсөв 1.5 сая төгрөг, Орон нутгийн төсөв 16,8 сая төгрөг; | Арга хэмжээнд хамруулсан иргэдийн тоо | 2024 онд бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд 15642 иргэнийг хамруулсан. | 2025 онд бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд 9003 иргэнийг хамруулж, A, B, C үнэлгээтэй иргэдийн тоог 67-оор нэмэгдүүлж ажиллана. | Тайлант онд хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд аймгийн хүн амын 3-64 насны 9034 иргэнийг хамруулснаас 77 иргэний бие бялдрын хөгжлийн түвшнийг сайжруулж 6805 иргэн буюу 75,3% нь A, B, C үнэлгээтэй байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй фитнесс клубүүдэд стандартын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулж, биеийн тамирын арга зүйчдийг чадавхжуулж ажилласан. | 100% |
| 1.1 | Арга хэмжээ-1: Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох | Улсын төсөв | | | Сорилд 9003 иргэнийг хамруулна. | Тайлант онд хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд 3-64 насны 9034 иргэдийг хамруулсан.Сорилд хамрагдсан иргэдээс 6805 иргэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сорилыг зохион байгуулж, дүн мэдээг программд нэгтгэн оруулж Биеийн тамир, спортын улсын хороонд хугацаанд нь хүргүүлэх; | 500,0 мянган төгрөг | Сорилд хамрагдсан иргэдийн тоо | Сорилд 8914 иргэнийг хамруулсан. | | буюу 75,3% нь A, B, C үнэлгээ авсан.Тухайлбал:<br>-А үнэлгээтэй 1240,<br>-В үнэлгээтэй 2351,<br>-С үнэлгээтэй 3215 иргэн байна. | |
| 1.2 | Арга хэмжээ-2:<br>Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэдийн түвшнийг сайжруулж, үр дүнг Биеийн тамир, спортын улсын хороонд хугацаанд нь хүргүүлэх; | Улсын төсөв 1,0 сая төгрөг | Сорилд хамрагдсан иргэдээс А, В, С үнэлгээтэй иргэдийн тоо | Сорилд хамруулсан иргэдээс А,В,С үнэлгээтэй иргэдийн тоо 6728 | A, B, C үнэлгээтэй иргэдийн тоог 6795 хүргэнэ. | Тайлант онд хүн амын дунд биеийн тамирын арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж 1,1 хувь буюу 77 иргэний бие бялдрын хөгжлийн түвшнийг сайжруулж 6805-д хүргэсэн. | 100% |
| 1.3 | Арга хэмжээ-3:<br>Сумдад ажиллах биеийн тамирын арга зүйчийн тоог нэмэгдүүлэх; | Орон нутгийн төсөв 16,8 сая төгрөг | Арга зүйчийн тоо | Баян-Өндөр суманд 1 арга зүйч ажилласан. | Сумдад ажиллах арга зүйчийн 1 орон тоог нэмэгдүүлж, Жаргалант суманд биеийн тамирын арга зүйч ажиллуулна. | Тайлант оны 02 дугаар сараас эхлэн Жаргалант суманд Ахмадын ордон, спорт заал хариуцсан орон тооны арга зүйчийг томилон тогтвортой ажиллуулсан. | 100% |
| | Арга хэмжээ-4:<br>Аж ахуйн нэгж, байгууллагад | - | Биеийн тамирын хамтлаг, | Биеийн тамирын хамтлаг-5, | Биеийн тамирын хамтлаг-6, | Тайлант онд аймгийн хэмжээнд 15 фитнес клубүүдтэй хамтран ажиллаж, өмнөх оноос арга зүйчийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.4 | биеийн тамирын хамтлаг, арга зүйчийн тоог нэмэгдүүлэх; | | арга зүйчийн тоо | арга зүйчийн тоо-10 | арга зүйчийн тоо-15 | тоог 6-аар, биеийн тамирын хамтлагийг 1-ээр тус тус нэмэгдүүлж, биеийн тамирын хамтлаг 6, арга зүйчийн тоо 16 болсон.Фитнес клубүүдийн 6 нь мэргэжлийн арга зүйчтэй, аж ахуйн нэгж байгууллагуудад спортын хамтлаг 6, сургуулийн өмнөх боловсролын 28 байгууллагуудад мэргэжлийн орон тооны багш ажиллаж хүүхэд багачууд, иргэдийг дасгал хөдөлгөөнд хамруулан, биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулж байна. | |
| 1.5 | Арга хэмжээ-5: Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа фитнес клубүүдтэй хамтран ажиллах, багш, дасгалжуулагч нарыг мэргэшүүлэх сургалтад хамруулах; | - | Сертификат авсан багш нарын тоо | - | Сургалт зохион байгуулж, гэрчилгээ олгосон байна. | Тайлант онд аймгийн хэмжээнд 15 фитнес клубүүдээс 11 фитнес клубт эрүүл ахуйн шаардлага, стандартыг хэрэгжүүлэх зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулж, заавар, зөвлөмж өгч ажилласан. Фитнес клубүүдийн арга зүйч, ажилтнуудад 2 удаа сургалт зохион байгуулж чадавхжуулж ажилласан.Үүнд:<br>-“Анхны тусламжийг иргэнд үзүүлэх” сэдэвт танхимын сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулсан. Тус сургалтад 15 байгууллагын 24 багш, дасгалжуулагч хамрагдсан.<br>-Спортын анагаах ухааны эрдэм шинжилгээний төвтэй хамтран "Идэвхтэй хөдөлгөөн, спортын бэлтгэл дасгалжуулалт, спортын | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гэмтэл, спортын био механик, өсвөрийн тамирчдын бие бялдрын хөгжлийн үе шатанд тохирсон сургалт дасгалжуулалт"-ыг 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулж, сургалтад фитнес клубүүдээс 5 арга зүйчийг хамруулсан .<br>Мөн төрийн албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, идэвхтэй хөдөлгөөнд хамруулах ажлын хүрээнд 7 фитнес клубтэй хамтран ажиллаж 392 албан хаагчийг 20-40% хөнгөлөлттэй үнээр хичээллүүлсэн. | |
| Стратеги төлөвлөгөөний зорилт-2.<br>Биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй нэг хэсэг болгож идэвхтэй хөдөлгөөнд хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлэх; | | | | | | | |
| Биеийн тамир, спортын тухай хуулийн 13.1, 14.1 заалт, Ахмад настны тухай хуулийн 11.1.2 заалт, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүний эрхийн тухай хуулийн 33.3 заалт, Соёл спорт аялал жуулчлал залуучуудын сайд, Орхон аймгийн Засаг даргатай 2025 онд байгуулсан гэрээний 4.7 заалт, Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.5.2, 3.5.5, 3.5.7, Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны | | Улсын төсөв 17,4 сая төгрөг, Орон нутгийн төсөв 80,4 сая төгрөг; | Арга хэмжээнд хамруулсан иргэдийн тоо | 2024 онд биеийн тамирын 60 арга хэмжээнд 46,520 иргэнийг хамруулсан. | 2025 онд биеийн тамирын 76 арга хэмжээг зохион байгуулж, 47000 мянган иргэнийг хамруулна. | Тайлант онд биеийн тамир, чийрэгжүүлэлтийн чиглэлээр 7 спортын холбоотой гэрээ байгуулан хамтран ажиллаж иргэд, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд биеийн тамир, чийрэгжүүлэлтийн арга хэмжээ, өглөөний дасгал, гүйлт, марафон гүйлт, алхалтын арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоог 3394-өөр нэмэгдүүлж, нийт 78 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 49,644 иргэнийг хамруулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| хөтөлбөрийн 2.3.1.1 заалт, Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө; | | | | | | | |
| 2.1 | Арга хэмжээ-1: Ахмад настнуудын биеийн тамир, спортын үйл ажиллагаанд оролцох оролцоо, хэрэглэл материалыг нэмэгдүүлж, дэмжлэг үзүүлэх; | Улсын төсөв 3,0 сая төгрөг | Тэмцээний тоо | Спортын 10 төрөлд 16 удаагийн арга хэмжээг зохион байгуулж 1200 ахмад настныг хамруулсан. | Спортын 11 төрөлд 16 удаагийн арга хэмжээг зохион байгуулж 1250 ахмад настныг хамруулна. | Тайлант онд ахмад настнуудын дунд спортын 11 төрлөөр 17 удаа тэмцээн, арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 1260 ахмад настныг хамруулсан.Аймгийн хэмжээнд төрийн болон төрийн өмчит байгууллага, ерөнхий боловсролын сургуулиудын спорт зааланд ахмад настнууд спортын 11 төрлөөр (софт волейбол, граунд гольф, бадминтон, хөл бөмбөг, дартс, шатар, даам, волейбол, ширээний теннис, хөнгөн атлетик) үнэ төлбөргүй секц дугуйланд хичээллэж нийт 430 ахмад тогтмол хамрагдаж байна. Аймгийн ахмад тамирчид улс, бүсийн аварга шалгаруулах граунд гольф, софт волейбол, ахмад мастеруудын спортын наадам зэрэг томоохон тэмцээнүүдэд тогтмол амжилттай оролцож байна. Тайлант онд спортын 10 төрөлд 107 ахмад тамирчин улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцож 8 алт, 7 мөнгө, 4 хүрэл медаль хүртэж, граунд гольфийн тэмцээнд 4 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тамирчин Алтан бөмбөгийн шагнал хүртсэн амжилтыг үзүүлсэн. | |
| 2.2 | Арга хэмжээ-2: Ахмад мастеруудын спортын VIII наадамд баг тамирчдыг оролцуулж амжилтыг нэмэгдүүлэх; | Улсын төсөв 2,4 сая төгрөг | Тамирчдын тоо | 2024 онд Ахмад мастеруудын спортын VII наадамд Орхон аймгаас спортын 8 төрөлд 80 тамирчин оролцож аймгуудаас 2-р байр эзэлсэн. | 8 төрөлд 80 тамирчин оролцуулж, амжилтыг нэмэгдүүлнэ. | Монголын мастеруудын спортын IX наадам 2025 оны 08 дугаар сарын 22-ний өдрөөс 08 дугаар сарын 24-ний өдрүүдэд Дархан-Уул аймагт зохион байгуулагдаж манай аймгаас спортын 8 төрөлд 86 тамирчин амжилттай оролцсон.<br>Тус тэмцээнээс хөнгөн атлетикийн төрөлд 1 алт, 2 мөнгө, 1 хүрэл медаль, граунд гольфийн төрөлд 4 тамирчин Алтан бөмбөгийн эзэд болсон.Бадминтоны спортын төрөлд ганцаарчилсан эрэгтэй, эмэгтэй, хос, холимог хосын төрөлд 7 алт, 6 мөнгө, 3 хүрэл медаль нийт 8 алт, 7 мөнгө, 4 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүлсэн. | 100% |
| 2.3 | Арга хэмжээ-3: Ахмад настан, тусгай хэрэгцээт иргэдийг спортоор хичээллэх, дасгал хөдөлгөөнд хамруулах нөхцөл боломжийг бүрдүүлж спортын заал танхимаар үнэгүй хангах; | - | Хамрагдсан иргэдийн тоо | 2024 онд 2 зааланд спортын 10 төрлөөр 750 иргэн тогтмол хичээллэсэн. | 2025 онд 760 иргэнд дасгал хөдөлгөөн, бэлтгэл сургуулилт хийх спортын заал, танхимаар хангана. | Тайлант онд төрийн болон төрийн өмчит байгууллагууд ерөнхий боловсролын сургуулиудын спорт заалнуудад 775 ахмад настан, тусгай хэрэгцээтэй иргэд биеийн тамир, спортоор хичээллэж байна Үүнд:<br>-Ахмад настнууд долоо хоногт 2-3 удаа өдөрт 2 цаг спортын 11 төрлөөр (софт волейбол, граунд гольф, бадминтон, хөл бөмбөг, дартс, шатар, даам, волейбол, ширээний теннис, хөнгөн атлетик) үнэ төлбөргүй секц дугуйланд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хичээллэж нийт 530 ахмад тогтмол хамрагдаж байна.<br>-Тусгай хэрэгцээт иргэд спортын 8 (бочи, сагсан бөмбөг, хонхот бөмбөг, суугаа волейбол, хөнгөн атлетик, ширээний дуут бөмбөг, цана, даам, хөл бөмбөг) төрлөөр спортын А, Б зааланд үнэ төлбөргүй хичээллэж давхардсан тоогоор 240 хүн хамрагдсан. | |
| 2.4 | Арга хэмжээ-4: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд оролцох оролцоо, хэрэглэл материалыг нэмэгдүүлж, дэмжлэг үзүүлэх; | Улсын төсөв 5,0 сая төгрөг | Зохион байгуулсан тэмцээн, өдөрлөгийн тоо | Биеийн тамир, спортын арга хэмжээг 9 төрлөөр 12 удаа тэмцээн зохион байгуулж давхардсан тоогоор 450 иргэнийг хамрагдсан. | Арга хэмжээг 9 төрлөөр 12 удаа тэмцээн зохион байгуулж давхардсан тоогоор 460 иргэнийг хамруулна. | Тайлант онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын 10 төрлөөр 13 удаа тэмцээн уралдаан, арга хэмжээ зохион байгуулж, оролцогчдын тоог өмнөх оноос 12-оор нэмэгдүүлж, давхардсан тоогоор 472 иргэдийг хамруулсан. Тэмцээн уралдаан, сургалт арга хэмжээний зардалд улс, орон нутгийн төсвийн 17,4 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан.Үүнд:<br>-Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын дагуу Монголын хүүхдийн спортын зуны VIII наадам 2025 оны 05 дугаар сарын 27-ний өдрөөс 06 дугаар сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулагдаж Орхон аймгаас пара, диф лимпийн спортын 7 төрлөөр 30 тамирчин амжилттай оролцож 4 алт, 3 мөнгө, 4 хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн.<br>-Хонхтой бөмбөгийн 9 дэх удаагийн улсын аварга шалгаруулах | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тэмцээнийг 2025 оны 06 дугаар сарын 07-ний өдрөөс 06 дугаар сарын 08-ны өдрүүдэд аймагтаа амжилттай зохион байгуулж, Улаанбаатар хот болон 8 аймаг, Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбооны эрэгтэй 10, эмэгтэй 6 багийн нийт 90 тамирчид оролцсон.<br>-Мөн Д.Түмэнбайгаль агсны нэрэмжит Суугаа волейболын аймгийн аварга шалгаруулах тэмцээн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Ширээний дуут бөмбөгийн аймгийн аварга шалгаруулах” тэмцээнийг зохион байгуулсан.<br>Спортын анагаах ухааны эрдэм шинжилгээний төвийн сургалт, судалгааны багтай хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс бие бялдрын ерөнхий хөгжил болон биеийн бүтэц, баланс, булчингийн ажиллах чадварыг тодорхойлох, эрүүл мэндийн ерөнхий үзлэг хийх, суурь судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулж хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний гэр бүл, асран хамгаалагчид нийт 75 хүн хамрагдаж зөвлөгөө мэдээлэл авсан. Мөн “Хүүхдийн ордон”-ы сургалтын танхимд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тамирчдад "Идэвхтэй хөдөлгөөн, спортын бэлтгэл дасгалжуулалт, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөв гүйх арга техник" сэдвээр сургалт зохион байгуулж, 30 хүнийг хамрагдсан. | |
| 2.5 | Арга хэмжээ-5: Дэлхийн Тусгай олимпын Зүүн ази бүсийн МАТР олон улсын сургалт, арга хэмжээг орон нутагтаа зохион байгуулах; | Орон нутгийн төсөв 60,0 сая төгрөг | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | Олон улсын сургалт арга хэмжээг зохион байгуулна. | Олон улсын Тусгай олимпын хорооноос “дэлхийн тусгай олимпын Зүүн ази бүсийн МАТР олон улсын сургалт, арга хэмжээ”-г Улаанбаатар хотод зохион байгуулахаар шийдвэрлэсэн. | - |
| 2.6 | Арга хэмжээ-6: “Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье” аяныг аймгийн иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын дунд өрнүүлэх; | Орон нутгийн төсөв 18,0 сая төгрөг | Дасгал хөдөлгөөнд хамрагдсан иргэдийн тоо | “Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье” аяныг зохион байгуулж, 42840 иргэнийг хамруулсан. | “Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье” аяныг зохион байгуулж, 43000 иргэнийг хамруулна. | Тайлант онд “Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье” аяны хүрээнд биеийн тамир, чийрэгжүүлэлт, спортын өдөрлөг, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд биеийн тамир чийрэгжүүлэлтийн 78 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 49,644 иргэнийг хамруулсан.Үүнд:<br>-Төрийн албан хаагчдын дунд “Ажлын байрны цахим дасгалын уралдаан”-д 42 байгууллагын давхардсан тоогоор 16,800 албан хаагч;<br>-Ерөнхий боловсролын сургуулиудын бага ангийн сурагчдын дунд “Нэг анги-Нэг өдөр” завсарлагааны цахим дасгалын уралдаанд 22 сургуулийн 196 бүлгийн давхардсан тоогоор 19,200 сурагчид; | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -“Төгөлдөр Солонго” бүжгийн клубтэй хамтран Шугаман бүжгийн сургалтад давхардсан тоогоор 2200 иргэд;<br>-“Эртэч эрдэнэтчүүд” өглөөний дасгалын арга хэмжээнд 2400 иргэд;<br>-Алхалтын 4 удаагийн арга хэмжээнд 785, гүйлтийн 2 удаагийн арга хэмжээнд 349 иргэдийг тус тус хамруулж ажилласан. | |
| 2.7 | Арга хэмжээ-7: “Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье” аяны хүрээнд Төрийн албан хаагчдын дунд “Цасны баяр” арга хэмжээг багийн болон үндэсний спортын 4 төрлөөр тэмцээн зохион байгуулах; | Орон нутгийн төсөв 2,4 сая төгрөг | Хамрагдсан баг, иргэдийн тоо | 26 байгууллагын 400 албан хаагч хамрагдсан. | 26 байгууллагын 400 албан хаагч хамруулна. | "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд төрийн байгууллагын албан хаагчдын дунд "Цасны баяр 2025" биеийн тамирын өдөрлөг арга хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Сархиа цанын баазад зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд олс таталт, хөгжөөнт буухиа, тэшүүрийн 4x100, гүйлтийн цанын 4x100 төрлүүдээр тэмцээн, уралдааныг зохион байгуулж, 16 байгууллагын 422 албан хаагчдыг хамруулсан. Тэмцээнийг орон нутгийн төсвийн 2,4 сая төгрөгийн хөрөнгөөр зохион байгуулсан. | 100% |
| 2.8 | Арга хэмжээ-8: “Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье” аяны хүрээнд бүх нийтийн гүйлтийн | Орон нутгийн төсөв 3,0 сая төгрөг, | Хамрагдсан иргэдийн тоо | 2 удаа зохион байгуулж 420 хүн хамрагдсан. | 2 удаа зохион байгуулж 450 хүн оролцуулна. | Тайлант онд бүх нийтийн гүйлтийн уралдааныг 2 удаа зохион байгуулж 349 иргэнийг хамруулсан.Үүнд:<br>-"Эрдэнэт марафон-2025" гүйлтийн уралдааныг 2025 оны 05 дугаар сарын 18-ны өдөр А.Амарын нэрэмжит талбайд төрийн болон | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | арга хэмжээ зохион байгуулах; | Улсын төсөв 1,0 төгрөг | | | | төрийн бус спортын холбоодтой хамтран зохион байгуулсан. Гүйлтийн уралдааныг 5 км, 10 км, 21 км, Гэр бүлийн гүйлт 1500м, Тусгай олимпын иргэдийн 500м-ийн зэрэг 5 зай төрөлд 7 насны эрэгтэй, эмэгтэй ангиллаар зохион байгуулж, Орхон, Булган, Хөвсгөл аймгийн нийт 239 тамирчид, иргэд оролцсон. Арга хэмжээнд орон нутгийн төсвийн 5,2 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан.<br>- Шри Чинмойны нэрэмжит бүх нийтийн гүйлтийг 2025 оны 09 дүгээр сард 4 км, 21 км-ийн зайд 7 насны эрэгтэй, эмэгтэй ангиллаар зохион байгуулж уралдаанд 110 тамирчдыг хамруулсан. | |
| 2.9 | Арга хэмжээ-9: “Иргэдийн спортын наадам”-ыг үндэсний болон багийн спортын 4 төрлөөр зохион байгуулах; | - | Зохион байгуулсан спортын төрлийн тоо | 2024 онд Иргэдийн спортын наадмыг Баян-Өндөр, Жаргалант сумын 26 багийн иргэдийн дунд багийн болон үндэсний спортын 8 төрлөөр зохион байгуулж 1163 иргэн хамруулсан. | Иргэдийн спортын наадмыг Баян-Өндөр, Жаргалант сумын 29 багийн иргэдийн дунд багийн болон үндэсний спортын 4 төрлөөр зохион байгуулна. | Аймгийн Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/1028 дугаар захирамжаар “Иргэдийн спортын наадам”-ыг спортын 4 /ширээний теннис олс таталт буудлага, олс таталт, корнхол/ төрлөөр тайлант оны 12 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулж 22 багийн 460 иргэдийг хамруулсан.Тэмцээний зардалд орон нутгийн төсвийн 12,1 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан. | 100% |
| 2.10 | Арга хэмжээ-10: Явган алхалтын аймгийн аварга шалгаруулах | Улсын төсөв 2,0 сая төгрөг | Хамрагдсан иргэдийн тоо | 2024 онд явган алхалтын арга хэмжээг 4 удаа зохион байгуулж | Явган алхалтын арга хэмжээг 5 удаа зохион | Аймгийн хэмжээнд 4 удаагийн алхалтын арга хэмжээг зохион байгуулж, 785 иргэнийг хамруулсан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тэмцээн болон алхалтын бусад арга хэмжээг зохион байгуулах; | | | 420 иргэнийг хамруулсан. | байгуулж, 440 иргэнийг хамруулна. | нь өмнөх оноос алхагчдын тоог 345-аар нэмэгдүүлсэн.Үүнд:<br>-Аймгийн Явган алхалтын холбоотой хамтран “Бүх хайраа гэр бүлдээ” урианы дор 100км замын алхалтын арга хэмжээг аймагтаа амжилттай зохион байгуулж, Дорнод, Багахангай, Архангай, Өвөрхангай, Дархан, Орхон аймаг,Улаанбаатар хотын нийт 95 алхагчдыг оролцуулан зохион байгуулсан.<br>-”Эрүүл Монгол Хүн" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Бүх нийтийн явган алхалт"-ын арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр А.Амарын талбайгаас Сархиа уулын чиглэлд зохион байгуулж, нийт 12 байгууллагын 210 албан хаагч, 300 гаруй иргэд оролцсон.<br>-Бурхан Багшийн Их Дүйчин өдрийг угтан “Эко гороо” алхалтыг 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулж, 60 гаруй иргэнийг хамруулсан.<br>-“Эрүүл мэнд-Эко гороо аялал” алхалтыг зохион байгуулж, алхалтад 120 иргэнийг хамруулсан. | |
| 2.11 | Арга хэмжээ-11: “Зөв гүйе” арга хэмжээг аймгийн хэмжээнд | Улсын төсөв 2,0 сая төгрөг | Сургалтад хамрагдсан багш нарын тоо | - | Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй "Эрүүл Монгол Хүн" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Зөв гүйж | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сурталчлан зохион байгуулах, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын биеийн тамирын багш нарт сургалт зохион байгуулах; | | | | биеийн тамирын багш нарыг хамруулна. | суръя" биеийн тамирын арга хэмжээг 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд Биеийн тамир, спортын газрын Б зааланд 7 хоног бүрийн Бямба, Ням гарагуудад өглөө бүр 07:20-08:30 цагуудад иргэдэд үнэ төлбөргүй зохион байгуулсан. Арга хэмжээнд 48 байгууллагын давхардсан тоогоор 500 гаруй иргэдийг хамруулсан. | |
| 2.12 | Арга хэмжээ-12: Идэвхтэй хөдөлгөөн, дасгалын ач холбогдлыг сурталчилж төрийн болон төрийн бус байгууллагуудад сургалт арга хэмжээ зохион байгуулах; | Улсын төсөв-2,0 сая төгрөг | Сургалт зохион байгуулсан тоо | 2024 онд 1 удаа сургалт зохион байгуулсан. | Идэвхтэй хөдөлгөөн, дасгалын ач холбогдлыг сурталчилсан сургалтыг 3 удаа зохион байгуулна. | Тайлант онд идэвхтэй хөдөлгөөн, дасгалын ач холбогдлын талаар 3 удаа сургалт зохион байгуулж, 156 биеийн тамирын арга зүйч, дасгалжуулагч, ажилтнуудыг хамруулсан.Үүнд:<br>-Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 15 фитнес клубийн ажилтнуудад “Анхны тусламжийг иргэнд үзүүлэх” сэдэвт танхимын сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулсан. Тус сургалтад 15 байгууллагын 24 биеийн тамирын арга зүйч, ажилтан хамрагдсан.<br>-Идэвхтэй хөдөлгөөн, дасгалын ач холбогдлыг сурталчлах, хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорил авах ажлын хүрээнд төрийн 5 байгууллага, 18 сургууль, цэцэрлэгийн албан хаагчдад 3 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | удаагийн сургалт, арга хэмжээг зохион байгуулж, нийт 75 биеийн тамирын багш, албан хаагчдыг хамруулсан.<br>-"Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд Спортын анагаах ухааны эрдэм шинжилгээний үндэсний төвтэй хамтран 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр “Идэвхтэй хөдөлгөөн ба ажлын байрны дасгал, Спортын гэмтлийн үед авах арга хэмжээ, Биеийн тамир, спортоор хичээллэгсэд өгөх зөвлөмж” сэдвүүдээр сургалт зохион байгуулсан.Сургалтад спортын дасгалжуулагч,биеийн тамирын арга зүйч, эмч, цэцэрлэгүүдийн биеийн тамирын багш, фитнес клубүүдийн багш, дасгалжуулагч 56 ажилтныг хамруулсан. | |
| 2.13 | Арга хэмжээ-13:<br>Иргэдэд эрүүл, идэвхтэй амьдралын зөв мэдлэг, хандлага, дадал суулгах талаар судалгаа авах ажлыг зохион байгуулах | - | Судалгаа авсан байх | - | Иргэдээс судалгаа авч дүгнэнэ. | Тайлант онд иргэдийн эрүүл, идэвхтэй амьдралын зөв мэдлэг, хандлагын талаарх ойлголтыг судлахаар 18 асуултыг бэлтгэж хариултыг сонгох хэлбэрээр бэлтгэсэн. Судалгааг gmail дээр суурилсан google.forum цахим технологийг ашиглан 2025 оны 04 сарын 14-ний өдрөөс 05 сарын 21-ний өдрийн хооронд авч, судалгааны үр дүнг дүгнэж 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллана. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.14 | Арга хэмжээ-14: Орон сууцны болон гэр хорооллын дундах спорт, чөлөөт цагийн талбайн ашиглалтыг сайжруулж биеийн тамир спортын уралдаан тэмцээнийг зохион байгуулах; | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2024 онд гадаа талбайд 13 удаа арга хэмжээ зохион байгуулж 7720 иргэнийг хамруулсан. | 2025 онд гадаа талбайд 13 удаа тэмцээн уралдаан, арга хэмжээ зохион байгуулж, 7800 иргэнийг хамруулна. | Тайлант онд амралт, чөлөөт цагийн талбайд зохион байгуулсан тэмцээн уралдаанд хамрагдсан иргэдийн тоог өмнөх оноос 110-аар нэмэгдүүлж, 17 удаагийн арга хэмжээнд 7910 иргэдийг хамруулсан.Үүнд:<br>-"Эртэч Эрдэнэтчүүд" өглөөний дасгалын арга хэмжээнд 2400 иргэн;<br>-Хүүхдийн баярын 06 дугаар сарын 01-ний өдрийн арга хэмжээний хүрээнд сагсан бөмбөгийн 3х3 төрөл, даамын тэмцээнд 500 хүүхэд;<br>-Бүх хайраа гэр бүлдээ арга хэмжээний нээлт, залуучуудын аймгийн аварга шалгаруулах спортын 8 төрөлт тэмцээнд 776 гаруй хүүхэд залуучууд;<br>-"Эрдэнэт марафон-2025", Шри Чинмойны нэрэмжит бүх нийтийн гүйлтийн 2 удаагийн арга хэмжээнд нийт 349 хүүхэд, залуучууд;<br>-Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын үдэлт, хаалтын арга хэмжээнд спортын 30 төрлийн 350 өсвөрийн тамирчид;<br>-"Эрүүл Монгол үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд "Бүх нийтийн явган алхалт"-н 4 арга хэмжээнд 785 иргэд; | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Эрдэнэт спорт амралтын хүрээлэн, Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн, Сархиа цанын баазад спортын 10 төрлийн тэмцээн уралдаанд 2750 иргэд, тамирчдыг тус тус оролцуулан зохион байгуулсан. | |
| 2.15 | Арга хэмжээ-15: Спортын хэрэгслийн /ердийн болон цахилгаан дугуй, цана, тэшүүр, дугуйт цана, дугуйт тэшүүр/ түрээсийн үйлчилгээг нэвтрүүлэх санал санаачилгыг дэмжих; | - | Түрээсийн үйлчилгээ үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийн тоо | 2024 онд 5 байршилд 6 иргэн, аж ахуйн нэгж спортын хэрэгслийн түрээсийн үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан. | 2025 онд спортын хэрэгслийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжин ажиллана. | Тайлант онд өвлийн спортын 3 байршилд 3 иргэн аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж, спортын хэрэгслийн түрээсийн үйлчилгээнд 4200 иргэдийг хамруулсан.Үүнд:<br>-Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-н Сархиа баазад цана чарганы түрээсийн үйлчилгээнд 2000 гаруй иргэн<br>-Эрдэнэт спорт амралтын хүрээлэнд тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд 1000 гаруй хүүхэд залуус<br>-Орос 19 дүгээр сургуулийн мөсөн талбайд тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд 1200 хүүхэд залуус тус тус үйлчлүүлсэн.<br>Спортын хэрэгслийн түрээсийн үйлчилгээ үзүүлэхэд зам талбайн орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор аймгийн Засаг даргын 2025 оны А/744 дүгээр захирамжаар салбар дундын “Ажлын хэсэг” байгуулан ажиллаж, хотын төвийн явган замаар унадаг дугуйтай иргэдийг чөлөөтэй зорчиход шаардлагатай 297,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг аймгийн 2026 оны төсөвт тусгуулж, батлуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Стратеги төлөвлөгөөний зорилт-3:<br>Монгол үндэсний уламжлалт спортыг орон нутагтаа хөгжүүлэх, сурталчлах, зохион байгуулах; | | | | | | | |
| Биеийн тамир, спортын тухай хуулийн 13.1, 14.1 заалт, Соёл спорт аялал жуулчлал залуучуудын сайд, Орхон аймгийн Засаг даргатай 2025 онд байгуулсан гэрээний 4.7 заалт, Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1.2 заалт, Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө; | | Орон нутгийн төсөв-20,0 сая төгрөг, Улсын төсөв-14,5 сая төгрөг; | Тэмцээн уралдаан арга хэмжээнд хамруулсан тамирчдын тоо | 2024 онд үндэсний спортын 6 төрөлд тэмцээн уралдаан зохион байгуулж 4359 тамирчдыг хамруулсан. | 2025 онд үндэсний спортын 6 төрлөөр тэмцээн уралдаан, арга хэмжээ зохион байгуулж, 4400 тамирчдыг хамруулна. | Тайлант онд үндэсний спортын /үндэсний бөх, шагай, мөсний сур, харваа мөсний шагай/ 5 төрлөөр 51 удаа тэмцээн уралдаан зохион байгуулж, 4428 тамирчдыг хамруулсан.Үндэсний спортын хичээллэгчдийн тоог 58-аар нэмэгдүүлж, 1048-д хүргэсэн. | 100% |
| 3.1 | Арга хэмжээ-1: Орон нутгийн онцлогт нийцүүлэн Үндэсний спортын төрлүүдийг сурталчилсан брэнд арга хэмжээг зохион байгуулах; | Орон нутгийн төсөв-20,0 сая төгрөг | Арга хэмжээний тоо | - | Үндэсний спортын төрлүүдийг сурталчилсан арга хэмжээг зохион байгуулсан байна. | Тайлант онд Орхон аймаг, Эрдэнэт хотоо сурталчилж дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор “Хойд бүсийн шагайн тойром-2025” тэмцээнийг зохион байгуулсан. Шагайн тойрмын тэмцээнд Булган, Хөвсгөл, Орхон аймгуудын 31 багийн 300 гаруй харваач цэц мэргэнээ сорин өрсөлдсөн Тэмцээнийг зохион байгуулахад орон нутгийн төсвийн 29,0 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан. | 100% |
| 3.2 | Арга хэмжээ-2: Үндэсний спортыг сурталчилсан “Нүүдэлчин” фестивальд оролцох; | Улсын төсөв-2.0 сая төгрөг | Арга хэмжээнд оролцсон спортын төрлийн тоо | 2024 онд үндэсний спортын 2 төрлөөр оролцсон. | 2025 онд үндэсний спортын 3 төрлөөр оролцоно. | Засгийн газрын 2024 оны 41 дүгээр тогтоолоор үндэсний спортыг сурталчилсан “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль 2025 оны 08 дугаар сарын 22-ний өдрөөс 08 дугаар сарын 24-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулагдаж, Орхон аймгаас үндэсний спортын 3 /үндэсний сур харваа, эмнэг булгиулагч, уран уургач/ төрөлд 16 тамирчинг оролцуулсан. | |
| 3.3 | Арга хэмжээ-3: “Үндэсний бөх-Монголын үнэт өв” арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулах; | Улсын төсөв 6,0 сая төгрөг | Зохион байгуулсан барилдааны тоо | 2024 онд үндэсний бөхийн барилдааныг өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн дунд зохион байгуулж, 2225 тамирчныг хамруулсан. | 2025 онд үндэсний бөхийн барилдааныг өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн дунд зохион байгуулж 2300 тамирчныг хамруулна. | Тайлант онд “Үндэсний бөх-Монголын үнэт өв” арга хэмжээг уламжлал болгон өсвөр үе, залуу цолтой болон цолгүй, насанд хүрэгчдийн 16 удаагийн барилдаанд 2432 бөхчүүдийг оролцуулан зохион байгуулсан. | 100% |
| 3.4 | Арга хэмжээ-4: Үндэсний спортыг өсвөр үе, хүүхэд багачуудад сурталчлан таниулах, өвлөн уламжлуулах зорилгоор “Цоллооч хүүхэд шалгаруулах уралдаан”-ыг зохион байгуулах; | Улсын төсөв-1,5 сая төгрөг | Уралдаанд хамрагдсан хүүхдийн тоо | 2024 онд “Цоллооч хүүхэд шалгаруулах уралдаан”-ыг 2 үе шаттай зохион байгуулж, 186 хүүхдийг хамруулсан. | “Цоллооч хүүхэд шалгаруулах уралдаан”-ыг 2 үе шаттай зохион байгуулж, 200 хүүхдийг хамруулна. | Тайлант оны 12 дугаар сард “Цоллооч” хүүхэд шалгаруулах уралдааныг зохион байгуулахаар төлөвлөсөн боловч Боловсролын сайдын 2025 оны 11 дүгээр сарын 25-ний өдрийн “Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчинд томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” 05 дугаар албан даалгаврын 2.7-д зааснаар “багш, хүүхдийг урлаг, спортын арга хэмжээнд оролцуулахыг зогсоосон” тул зохион байгуулах боломжгүй болсон. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.5 | Арга хэмжээ-5: Үндэсний спортын төрлүүдээр тэмцээн уралдаан зохион байгуулж, оролцогчдыг нэмэгдүүлэх; | Улсын төсөв-5,0 сая төгрөг | Зохион байгуулсан тэмцээний тоо | 2024 онд үндэсний спортын 5 төрөлд тэмцээн уралдаан зохион байгуулж 2134 тамирчдыг хамруулсан. | 2025 онд үндэсний спортын 5 төрлөөр тэмцээн уралдаан зохион байгуулж 2200 тамирчдыг хамруулна. | Тайлант онд үндэсний спортын /үндэсний бөх, шагай харваа, мөсний сурын харваа, үндэсний сурын харваа, мөсний шагайн харваа/ 5 төрлөөр 51 удаа тэмцээн уралдаан зохион байгуулж, оролцогчдын тоог өмнөх оноос 2294-өөр нэмэгдүүлж, 4428 тамирчдыг хамруулсан.<br>Үүнд:<br>-Үндэсний бөхийн барилдааныг 16 удаа тэмцээн зохион байгуулж, 2432 өсвөр, залуу бөхчүүд;<br>-Шагайн харвааны тэмцээн 5 удаа зохион байгуулж, нийт 736 харваачид;<br>-Мөсний сур харвааны 2 тэмцээн 104 тамирчин, Буриад сурын харвааны 3 удаагийн тэмцээнд 76 тамирчин, Урианхай сурын харвааны 4 тэмцээнд 114 тамирчин, Саранпай харвааны 2 тэмцээнд 80 тамирчин, Үндэсний сурын харвааны 2 тэмцээн зохион байгуулж 126 тамирчин нийт 13 тэмцээн зохион 700 тамирчин хамрагдсан.<br>-Мөсний шагайн харвааны төрлөөр 5 тэмцээн зохион байгуулж нийт 560 тамирчин хамрагдсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Стратеги төлөвлөгөөний зорилт-4:<br>Спортын сургалтын дасгалжуулалтын үйл ажиллагааг сайжруулж, тамирчдын авьяасыг нээн илрүүлэх, тэдэнд дэмжлэг үзүүлэн, тэмцээн уралдаанд оролцох оролцоог нэмэгдүүлж, амжилт гаргах нөхцөлийг бүрдүүлэх; | | | | | | | |
| Биеийн тамир, спортын тухай хуулийн 13.1, 14.1 23.5 заалт, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоол, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Орхон аймгийн Засаг даргатай 2025 онд байгуулсан гэрээний 4.7 заалт, Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.5.3, 3.5.4 заалт, Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1.2, 2.3.1.3 заалт, Аймгийн Засаг даргын 2015 оны А/445 дугаар захирамж, Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө; | | Улсын төсөв-20,0 сая төгрөг, Орон нутгийн төсөв-636,1 сая төгрөг; | Тэмцээн уралдаанд оролцогчдын тоо | 2024 онд дэлхий, тив, олон улс, улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээнд Орхон аймгаас 1100 тамирчин оролцож, 758 тамирчид медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн. | Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолоор улсын хэмжээнд зохион байгуулагдах спортын наадмуудад баг тамирчдыг оролцуулж, тэмцээн уралдаанд оролцогчдын тоог нэмэгдүүлнэ. | Тайлант онд аймгийн хэмжээнд спортын 35 төрлөөр 145 удаагийн тэмцээн уралдаан зохион байгуулж, давхардсан тоогоор 21,600 иргэнийг хамруулсан. Орхон аймгийн тамирчид 2025 онд дэлхий, тив, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнээс 537 медаль авсан амжилтыг үзүүлсэн. Үүнд: алтан медаль 165, мөнгөн медаль 139, хүрэл медаль 233.<br>Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолоор улсын хэмжээнд зохион байгуулагдсан Монголын бүх ард түмний зуны спортын XVI наадамд 1-р байр, Монголын хүүхдийн спортын зуны VIII наадамд 1-р байр, өвлийн төрөлд 2-р байранд шалгарсан амжилтыг тус тус үзүүлсэн.Тэмцээн уралдаан,тамирчдын урамшуулал, хэрэглэл материалд улсын төсвийн 40,0 сая төгрөг, орон нутгийн төсвийн 1 тэр бум, 167,5 сая төгрөгийн хөрөнгийг тус тус зарцуулсан. | 100% |
| 4.1. | Арга хэмжээ-1:<br>Олон улс, улс, бүсийн түвшинд өрсөлдөх Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн | Орон нутгийн төсөв 57,2 сая төгрөг | Гэрээт дасгалжуулагчдын тоо | - | Өсвөрийн шигшээ багуудад 2-оос доошгүй гэрээт дасгалжуулагч ажиллуулж, | Тайлант онд аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ 16 багт 196 өсвөрийн тамирчин бэлтгэл сургуулилалт хийж байна.Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг сайжруулж хүндийн өргөлт, хөнгөн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шигшээ багуудад гэрээт дасгалжуулагчийг ажиллуулж, хэрэглэл материалаар хангах; | | | | хэрэглэл материалаар хангасан байна. | атлетикийн төрлүүдэд гэрээт дасгалжуулагчдыг ажиллуулсан. Монголын хүүхдийн спортын зуны VIII дугаар наадмын анхан шатны тэмцээнийг спортын 20 төрлөөр зохион байгуулж, нийт 2146 тамирчин, шигшээ тэмцээнд Орхон аймгаас спортын 30 төрөлд 297 тамирчин, 51 дасгалжуулагчдыг бэлтгэн оролцуулж, алтан медаль 15, мөнгөн медаль 15, хүрэл медаль 25, нийт 55 медаль авч, 21 аймгийн багийн дүнгээр 1-р байр, өвлийн наадмын 6 төрөлд Орхон аймгаас 75 тамирчин, 10 дасгалжуулагчийг бэлтгэн оролцуулж, багийн дүнгээр 2-р байр эзэлсэн амжилтыг тус тус үзүүлсэн. Өсвөрийн шигшээ баг тамирчдыг тэмцээн уралдаанд оролцуулахад улсын төсвийн 20,0 сая төгрөг, орон нутгийн төсвийн 274,5 сая төгрөг, буудлагын шигшээ багт иж бүрэн тоног төхөөрөмжийг орон нутгийн төсвийн 230,5 сая төгрөгийн хөрөнгөөр худалдан авсан. | |
| 4.2. | Арга хэмжээ-2: Аймгийн Засаг даргын 2015 оны А/445 дугаар захирамжийн дагуу | Орон нутгийн | Тив, дэлхий, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнээс | 2023 онд дэлхий, тив, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнээс медаль хүртсэн 444 тамирчин, спортын | 2024 онд дэлхий, тив, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнээс медаль хүртсэн | Аймгийн Засаг даргын 2015 оны А/445 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу<br>2024 онд өндөр амжилт гаргасан 432 тамирчин, спортын шилдэг 8 төрийн бус байгууллага, 5 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2024 онд спортын өндөр амжилт гаргасан тамирчин, түүний дасгалжуулагчдад жил бүр мөнгөн урамшуулал олгох; | төсөв 77,9 сая төгрөг | медаль авсан тамирчдын тоо | шилдэг 5 төрийн бус байгууллагад нийт 51,7 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон. | тамирчдад батлагдсан төсвийн хүрээнд мөнгөн урамшуулал олгоно. | дасгалжуулагчдад аймгийн Засаг даргын 2025 оны А/889 дүгээр захирамжаар 78,5 сая төгрөгийн мөнгөн урамшууллыг олгосон. | |
| 4.3 | Арга хэмжээ-3:<br>Улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулах; | Орон нутгийн төсөв-30,0 сая төгрөг | Зохион байгуулсан тэмцээний тоо | 2024 онд 5<br>удаа улс, бүсийн чанартай томоохон тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулсан. | 2025 онд 5 удаа улс, бүсийн чанартай томоохон тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулна. | Тайлант онд улсын аварга шалгаруулах 9, олон хотын болон бүсийн чанартай 6 тэмцээн нийт улс, бүсийн 15 удаагийн тэмцээн зохион байгуулж, 4627 тамирчдыг хамруулсан.Тэмцээн уралдаан зохион байгуулахад орон нутгийн төсвийн 52,5 сая төгрөг зарцуулсан.Үүнд:<br>-Монголын үндэсний Мөсний шагайн шилдэг багуудын аварга шалгаруулах "Эрдэнийн цом" тэмцээнд 8 аймгийн 35 багийн 210 харваач;<br>-“Ах дүү 4 Мастерын нэрэмжит” 2025 оны хөл бөмбөгийн ахмадын улсын аварга шалгаруулах, тэмцээнд 12 багийн 120 тамирчид;<br>-"Мөрөөдлийнхөө төлөө-Шударгаар өрсөлдье" урианы дор Монголын Хүүхдийн спортын өвлийн VIII их наадмын цанын спортын 4 төрлийн тэмцээнийг аймагтаа амжилттай зохион байгуулж, тэмцээнд 13 аймаг, 6 дүүргийн 209 тамирчид;<br>-Гүйлтийн цанын насанд хүрэгчдийн 2025 оны улсын аварга | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалгаруулах тэмцээнд 10 аймаг, 4 дүүргийн 110 тамирчид;<br>-Усанд сэлэлтийн өсвөр үе, залуучуудын 2025 оны улсын аварга шалгаруулах тэмцээнд 32 клубын 600 тамирчид;<br>-Сагсан бөмбөгийн 5x5 төрлийн U18 насны 2025 оны улсын аварга шалгаруулах тэмцээнд 36 багийн 560 өсвөрийн тамирчид;<br>-Авто спортын “Ice drift-2025” улсын аварга шалгаруулах тэмцээнд 50 гаруй тамирчид;<br>- Мөсний сурын харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 6 аймгийн 70 харваач;<br>- Бадминтоны өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, 60 багийн 360 тамирчид;<br>-Эрдэнэт мөнгөн өвөл-2025 аяны хүрээнд гүйлтийн цанын өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээнд 10 аймаг, 2 дүүргийн 100 гаруй тамирчид;<br>-Гүйлтийн цанын “Клубуудын аварга шалгаруулах” тэмцээнд 8 аймаг, 2 дүүргийн 100 гаруй тамирчид;<br>-“Эрдэнэтийн-Од” олон хотын аварга шалгаруулах нээлттэй тэмцээнд 52 багийн 648 өсвөрийн тамирчид;<br>-Атланта-96” олимпын наадмын хүрэл медальт, Монгол Улсын гавьяат тамирчин Д.Нармандахын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэрэмжит “Жүдо бөхийн өсвөр үеийн олон хотын аварга шалгаруулах тэмцээн”-д 62 багийн 1100 тамирчид;<br>-“Хойд бүсийн шагайн тойром-2025” тэмцээнд Булган, Хөвсгөл, Орхон аймгуудын 31 багийн 300 гаруй харваач тус тус оролцсон. | |
| 4.4 | Арга хэмжээ-4: Монголын Хүүхдийн спортын өвлийн VIII наадамд Орхон аймгаас баг тамирчдыг оролцуулах; | Орон нутгийн төсөв-35,7 сая төгрөг | Спортын наадмаас авсан медалийн тоо | 2023 онд зохиогдсон Монголын Хүүхдийн спортын өвлийн VII наадамд спортын 5 төрөлд 54 тамирчин оролцуулж, багийн дүнгээр 4-р байранд шалгарсан. | Монголын Хүүхдийн спортын өвлийн VIII наадамд спортын 5 төрөлд баг тамирчдыг бэлтгэн оролцуулна. | Монголын Хүүхдийн спортын өвлийн VIII наадамд Орхон аймгаас 5 төрөлд 73 тамирчин, 10 дасгалжуулагчийг бэлтгэн оролцуулж, 10 алт 13 мөнгө 9 хүрэл нийт 32 медаль хүртсэн амжилтаар аймгуудын багийн дүнгээр 2-р байр эзэлж, цом, өргөмжлөлөөр шагнагдсан.Баг тамирчдыг тэмцээн уралдаанд оролцуулахад орон нутгийн төсвийн 35,7 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан.Монголын хүүхдийн спортын өвлийн VIII наадамд Орхон аймгийн өсвөрийн тамирчдын үзүүлсэн амжилт нь анх удаа өвлийн наадамд байр эзэлсэн амжилт юм. | 100% |
| 4.5 | Арга хэмжээ-5: Монголын хүүхдийн спортын өвлийн VIII наадмын цанын төрлүүдийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн | - | Наадмын цанын төрлүүдийг зохион байгуулсан байх | 2023 онд Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадмыг зохион байгуулсан. | 2025 онд Монголын хүүхдийн спортын өвлийн VIII наадмын цанын төрлүүдийг | "Мөрөөдлийнхөө төлөө-Шударгаар өрсөлдье" урианы дор Монголын Хүүхдийн спортын өвлийн VIII наадмын цанын спортын 4 төрлийн тэмцээнийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороотой | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тамир, спортын улсын хороотой хамтран зохион байгуулах; | | | | зохион байгуулна. | хамтран Сархиа цанын баазад 2025 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс 02 дугаар сарын 20-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулсан.Цанын төрлийн тэмцээнд 13 аймаг, 6 дүүргийн 209 тамирчид оролцсон.Тэмцээнийг зохион байгуулахад улсын төсвийн 20,0 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан. | |
| 4.6 | Арга хэмжээ-6: Монголын Хүүхдийн спортын зуны VIII наадмын анхан шатны аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах; | Орон нутгийн төсөв-20,0 сая төгрөг | Зохион байгуулсан тэмцээний тоо | 2023 онд зохиогдсон Монголын Хүүхдийн спортын зуны VII наадмын хүрээнд анхан шатны аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 15 төрлөөр зохион байгуулсан. | Монголын Хүүхдийн спортын зуны VIII наадмын хүрээнд анхан шатны аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 15 төрлөөр, сорилоор 5 төрлөөр тус тус зохион байгуулж, шигшээ тэмцээнд оролцох тамирчдыг шалгаруулна. | Монголын хүүхдийн спортын зуны VIII дугаар наадмын анхан шатны тэмцээнийг спортын 20 төрлөөр зохион байгуулж, нийт 2146 тамирчин хамруулсан. | 100% |
| 4.7 | Арга хэмжээ-7: Монголын Хүүхдийн спортын зуны VIII наадмын шигшээ | Орон нутгийн | Спортын наадмаас | 2023 онд зохиогдсон Монголын Хүүхдийн спортын зуны VII | Монголын Хүүхдийн спортын зуны VIII наадамд | Монголын хүүхдийн спортын зуны VIII дугаар наадмын шигшээ тэмцээнд Орхон аймгаас спортын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тэмцээнд Орхон аймгаас баг тамирчдыг оролцуулах; | төсөв-167,5 сая төгрөг | авсан медалийн тоо | наадамд 20 төрөлд 217 тамирчин оролцож, 21 аймгийн багийн дүнгээр 2-р байр эзэлсэн. | спортын 20-оос доошгүй төрөлд баг тамирчдыг бэлтгэн оролцуулна. | 30 төрөлд 297 тамирчин, 51 дасгалжуулагчдыг бэлтгэн оролцуулж, алтан медаль 15, мөнгөн медаль 15, хүрэл медаль 25, нийт 55 медаль хүртсэнээр 21 аймгийн багийн дүнгээр 1-р байранд шалгарч цом, өргөмжлөлөөр шагнагдсан амжилтыг үзүүлсэн.Тэмцээнд оролцсон тамирчдын зардалд орон нутгийн төсвийн 167,0 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан. | |
